



НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар

1069

Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2, 109 дүгээр зүйлийн 109.1, дэх заалт, Эрүүл мэндийн яамны 2022 оны 5/453 тоот бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд Амгалан амаржих газарт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн оройн 19.00 цагаас 2022 оны 02 дугаар сарын 07-ны өглөөний 08.00 цаг хүртэл ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, Эрүүл мэндийн яаманд өгөх мэдээний хүснэгтийг хоёрдугаар, хариуцлагатай эргүүлийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцлагатай жижүүр, албаны дарга, тасгийн эрхлэгч, хэсгийн ахлагч, ахлах эх баригч, ахлах сувилагч нарт Даалгах нь:

2.1. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр нь тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг хоёрдугаар хавсралтад заасан мэдээний хүснэгтийн дагуу өглөө бүр 07.00, орой бүр 20.00 цагт Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын 99700420 дугаарын утсанд шуурхай мэдээллэх,

2.2. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь тухайн өдрийн мэдээг нэгтгэн амаржих газрын Захирлын 91916585 дугаарын утсанд өдөрт 1 удаа, онцгой тохиолдолд тухай бүрт нь шуурхай мэдээлэх,

2.3. Амралтын өдрүүдэд тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг тухайн өдрийн жижүүрийн ахлах эмч нар Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан АМ-36 маягтын Статистикч, мэдээлэл зүйн албаны Статистикч Б.Мягмарсүрэнгийн 99786074 дугаарын утсанд өглөө бүр 07:00 цагт мэдээ өгөх, мэдээг нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд өдөр бүрийн өглөөний 08.00 цагт www.burtgel.mohs.mn цахим хаягаар оруулахыг үүрэг болгосугай.

2.4. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчлийг гаргахгүй байх, байнгын хяналт тавьж ажиллах,